

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**
(2022 оны жилийн эцэс)

2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
1	2	3	4	5	6	7
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ						
1	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	48 удаагийн сургалт (2021 оны нийт сургалтын тоо)	49 удаагийн сургалт	1.Нийт 94 удаагийн сургалтад (цахимаар 48, танхимын 46) нийт давхардсан тоогоор 713 албан хаагч хамрагдав. Үүнээс 4 цагаас дээш 49 удаагийн сургалтад давхардсан тоогоор 130 албан хаагч хамрагдсан байна. Эрэгтэй албан хаагчийн тоо 58, эмэгтэй албан хаагчийн тоо 72.
		Үүн ээс	Ажлын байран дахь сургалт	5-аас доошгүй	6 сургалт 85 албан хаагч	2.Ажлын байранд Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Архивын газар, JCI ТББ, Super Jump сургалтын байгууллагатай хамтран 6 удаагийн сургалтыг зохион байгуулав.
			Мэргэшүүлэх сургалт	5		
			Туршлага солилцох арга хэмжээ	1		
			Бусад	-		
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	100 албан хаагч	130 (давхардсан тоогоор)	3.Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс албан хаагчид бусад алба, хэлтсийн үйл ажиллагаатай танилцах, байгууллагын хамт олны уур амьсгалыг нэгтгэх зорилгоор мэргэжилтэн солилцох хөтөлбөрийг 14 хоногийн хугацаанд хэрэгжүүлэв. 4. Нэгжүүдийн дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийг гүйцэтгэхэд тулгарч буй асуудлуудыг хамтран хэлэлцэж, тус асуудлуудыг шийдвэрлэх гарц, шийдэл, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Асуудал ба шийдэл” хэлэлцүүлгийг
		Үүн ээс	Эмэгтэй албан хаагч	-	58	
			Эрэгтэй албан хаагч	-	72	
			Удирдах албан тушаалтан	-	21	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	109	
		1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	100 хувь хамрагдсан	

2	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	2-3 сургалт	6 сургалт, семинар	Гадаад улсад зохион байгуулагдсан сургалт, семинар, хурал зөвлөгөөнд Газрын даргын тушаалаар 6 удаагийн сургалтад 8 албан хаагч хамрагдав. - БНСУ-д "Түрээсийн орон сууцны бодлого, санхүүжилт" сэдэвт сургалтад 1 албан хаагч, - БНСУ-д "Нийтийн орон сууцны барилгын зураг төсөл, төслийн менежмент" сэдэвт сургалтад 1 албан хаагч, - БНСУ-д Солонгосын Архитектурын хүрээлэнгээс зохион байгуулсан "KIA Convention & Exhibition 2022" үзэсгэлэн, хурал, семинарт 2 албан хаагч, - Филиппин улсад "Улаанбаатар хотын захиргааны албан хаагчдад зориулсан Азийн хөгжлийн банкны хамгаалалтын бодлого" сургалт, танилцах аялалд 2 албан хаагч, - Япон улс, "Japan Build Expo 2022" танилцах аяллын хөтөлбөрт 1 албан хаагч, - Сингапур улс, "Олон улсын залуу архитектор, хот төлөвлөгч, салбарын мэргэжилтнүүдийн төслийн танилцуулга, чөлөөт уулзалт"-д 1 албан хаагч тус тус хамрагдав.
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	2-3 албан хаагч	8	
		Үүн ээс	Эмэгтэй албан хаагч	-	5	
			Эрэгтэй албан хаагч	-	3	
			Удирдах албан тушаалтан	-	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	7	
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	3.135.0 мян.төг	1,040.0 мян.төг (байгууллагын зардлаар, 13 албан хаагч) 15,375.8 мян.төг (хувийн зардлаар, 17 албан хаагч)	Байгууллагын зөвшөөрлөөр мэргэшэх сургалтад 17 албан хаагч хувийн зардлаар (15,375,800 төгрөг) суралцсан бөгөөд байгууллагаас цалинтай чөлөө олгож, суралцах нөхцөл боломжоор хангасан. Үүнд: 1. Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1 удирдах албан тушаалтан хамрагдаж 1 гэрчилгээ, (1,620,000 төгрөгийг хувийн зардлаар) 2. Ахлах түшмэлийн багц сургалтад 6 албан тушаалтан хамрагдаж, 6 гэрчилгээ, (1 албан хаагчийн 1,620,000 төгрөг, 9,720,000 төгрөгийг хувийн зардлаар) 3. Мэргэшсэн архитектор, инженерийн зэрэг горилох болон үргэлжилсэн сургалтад 8 албан хаагч хамрагдаж 7 гэрчилгээ, (сургалтын төлбөрт 3,175,800 төгрөгийг хувийн зардлаар) 4. Зөвлөх инженерийн зэрэг горилох болон үргэлжилсэн сургалтад 2 албан хаагч (сургалтын төлбөрт 860,000 төгрөгийг хувийн зардлаар) Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 13 албан хаагч хамрагдаж 6 гэрчилгээ, (1 албан хаагчийн

						80,000 төгрөг, нийт 1,040,000 төгрөгийг байгууллагын зардлаар)
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	29% 28 албан хаагч	Ажлаас чөлөөлөгдсөн 28 албан хаагчаас төрийн захиргааны албан хаагч 23, төрийн үйлчилгээний албан хаагч 5. Үүнээс: 1. ТАТХ-ийн 44.1 дэх заалт буюу байгууллага хооронд шилжин томилогдсон 3 албан хаагч, 2. ТАТХ-ийн 46.1.1 дэх заалт буюу эрүүл мэндийн шалтгаанаар 3 албан хаагч 3. ТАТХ-ийн 46.1.2 дахь заалт буюу сургалтаар 3 албан хаагч, 4. ТАТХ-ийн 46.2.2 дахь заалт буюу тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 1 албан хаагч, 5. ТАТХ-ийн 46.2.4 дэх заалт буюу өөрийн хүсэлтээр 6 албан хаагч, 6. Төрийн хэмнэлтийн тухай хууль удирдах албан тушаалтан 2, 7. ХТХ-ийн 78.1.9 дэх заалт ажилтны санаачилгаар болон бусад түр орон тоонд ажиллаж байсан 10 албан хаагч.
АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ						
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	Жилдээ	1,248,633,7 мян.төг цалин 43% 96.683.2 мян. төг Мөнгөн урамшуулал давхардсан тоогоор 161 албан хаагч	1.Цалин 1,248,633,759 төгрөг 2.“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2022 оны эхний хагас ажлын үр дүнгээр “Маш сайн”, “Сайн” үнэлэгдсэн 83 албан хаагчид Газрын даргын 2022 оны Б/64 дүгээр тушаалаар үр дүнгийн 49,583,928 төгрөгийн, сүүлийн хагас жилд “Маш сайн”, “Сайн” үнэлэгдсэн 78 албан хаагчид Газрын даргын 2022 оны Б/145 дугаар тушаалаар үр дүнгийн 47,099,352 төгрөгийн урамшуулал олгов.
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	Жилдээ	94,858,2 мян.төг	Нийслэлээс баталсан төсвийн хүрээнд нэг албан хаагчид өдрийн хоолны мөнгө 4500 төгрөг, унааны зардал 500 төгрөгийг тус тус олгож байна. Хоол 85.997.2 мян.төг Унаа 8,861,0 мян.төг
5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	82% 68 албан хаагч	Ажиллах нөхцөл, ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн судалгааг цаасаар болон googleform цахим

						судалгаанд 68 албан хаагч хамрагдав.
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	-	2022 онд албан хаагчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төсөв батлагдаагүй болно. МУ-ын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Эрт илрүүлэг 2022” үзлэг шинжилгээнд албан хаагчдын идэвхтэй хамрагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллав.
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	22 албан хаагч	МУ-ын Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй “Эрт илрүүлэг 2022” үзлэг шинжилгээнд 22 албан хаагч хамрагдсан.
7	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Жилдээ	15,039,6 мян.төг	Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 68 албан хаагчийн 16 хүртэлх насны 135 хүүхдэд Эх үрсийн баярыг тохиолдуулан Газрын даргын 2022 оны 45 дугаар тушаалаар бэлэг өгөх хөрөнгийг шийдвэрлэв. (1 хүүхэд 40,000 төгрөг, нийт 5.400.000 төгрөг) Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 21 албан хаагчид 6,450,000 (төгрөгийн тэтгэмж, цалинтай чөлөөг 14 албан хаагчид, (61 ажлын хоног), цалингүй чөлөөг 20 албан хаагчид (278 ажлын хоног) тус тус Газрын даргын тушаалаар олгов. Албан ажлын шаардлагаар хувийн унаа хэрэглэсэн 45 албан хаагчид 3,189,621 төгрөгийн нөхөх төлбөр олгов.

ТАНИЛЦСАН: ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН: ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ц.ТУЛГА

Н.БАДАМХАНД

Т.БУЯНЖАРГАЛ